**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/435 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 23/01, 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 9/36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хавсралтад заасан 112.780.000 /нэг зуун арван хоёр сая долоон зуун наян мянга/ төгрөгийг нийслэлийн 2020 оны төсөвт тусгасан Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү /-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Уртнасан/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

1110200003362

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/425 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн | Хамтрагч |
| **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | | | |
| 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулна. | 1 дүгээр улиралд | | | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| | 2 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт, албан төрийн албаны зөвлөлөөс баталсан албан тушаалын тодорхойлолтыг олон нийтэд ил тод, нээлттэй болгоно. | Жилдээ | | | Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байна. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг | 3 | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно. | Жилдээ | | | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилж, батлуулсан байна. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| | 4 | Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна. | Жилдээ | | | Ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байна. | ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөл | ННЗБ-ууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| баримтлан томилох, дэвшүүлэх | 5 | Төрийн жинхэнэ албан тушаалын "Ерөнхий мэдлэгийн шалгалт-ыг зохион байгуулна. | 1, 4 дүгээр улиралд | | | Төрийн жинхэнэ албан тушаалын хүний нөөц нэмэгдсэн байна. | ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөл | ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөл |
| 4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагаа үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | 6 | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох олон улсын тогтолцоо (ISO 9000)-г нэвтрүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. | Жилдээ | | | Төрийн байгууллагад олон улсын тогтолцоо нэвтэрнэ. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.1.5.авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг батлаж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх | 7 | Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авна. | Жилдээ | АТҮХ-ийн хэрэгжүүлэх зардал | 15.000.000 | Авлигын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| 4.1.1.6.нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх | 8 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна. | Жилдээ | АТҮХ-ийн хэрэгжүүлэх зардал | 10.000.000 | Байгууллагуудын Ёс зүйн хорооны шийдвэрийн санг бүрдүүлсэн байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| 4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага | 9 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ. | Жилдээ | | | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | | | | | | ажиллагааны үр дүн сайжирсан байх | | |
| 4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 10 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа 46 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Жилдээ | Батлагдсан төсөв | | Иргэд төрийн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдэнэ. | НМТГ | ННЗБ-ууд |
| 4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 11 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулна. | Жилдээ | АТҮХ-ийн хэрэгжүүлэх зардал | 12.630.000 | Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар нэмэгдсэн байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | АТГ, Сургалтын байгууллагууд |
| | 12 | Дүүрэг, хороодын албан хаагчдад зориулсан сэдэвчилсэн, зорилтот, цахим сургалтыг зохион байгуулна. | Жилдээ | Батлагдсан төсөв | | | НЗДТГ-ын дэргэдэх Сургалт судалгааны төв. | Сургалтын байгууллагууд |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 13 | Газрын дуудлага худалдааг газрын биржийн цахим системээр зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангана. | Жилдээ | Нийслэлийн төсөв | 295 000 000 | Газар олголтыг журмын дагуу зохион байгуулж иргэдийн эрх тэгш байдал хангагдана | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |
| | 14 | Газрын бичиг баримтыг цахимжуулан цахим мэдээллийн сан үүсгэнэ. | Жилдээ | Үйл ажиллагаан ы зардал | | Газартай холбоотой баримт бичгүүд цахим хэлбэрт шилжиж, иргэд газрын мэдээлэлтэй танилцах боломж нэмэгдэнэ. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |
| | 15 | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг Газрын биржийн цахим систем, Газрын кадастрын мэдээллийн санд суурилан цуглуулах ажлыг зохион | Жилдээ | Үйл ажиллагаан ы зардал | | Мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл нээлттэй болсон байх | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах, олон нийтэд ил тод болгоно. | | | | | | |
| | 16 | Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн сан, цахим системийг турших, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Жилдээ | Үйл ажиллагааны зардал | | | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |
| | 17 | Газрын кадастрын мэдээллийн сангийн "Лэнд менежер" програм хангамжийн веб хувилбарыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Жилдээ | Үйл ажиллагааны зардал | | | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |
| 4.1.2.5.Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах | 18 | Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвүүдээс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын судалгаа хийх, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. | 4 дүгээр улиралд | АТҮХ-ийг хэрэгжүүлэх зардал | 15 000 000 | Судалгааг мэргэжлийн байгууллага холбоодоор гүйцэтгүүлж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Судалгааны байгууллага |
| 4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | 19 | Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна. | | | | Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулна. | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |
| | 20 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн, батлуулж, дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэсний хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулж, програм хангамжийн сургалтуудыг зохион байгуулан ажиллана. | | | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн, батлуулна. | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |
| | 21 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн | | | | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих өдөр тутмын хяналтыг сайжруулж, | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишгийг тогтоолгоход анхаарч ажиллана. | | | | хугацаа хэтрүүлэхгүй байх, хугацаа дөхсөн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай шаардлага тавьж ажиллана. | | |
| | 22 | Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлж, иргэнд хариу өгнө. | | | | Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөн эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, иргэнд хариу өгч, тайланг гаргана. | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |
| 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | 23 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. | Жилдээ | АТҮХ-хэрэгжүүлэх зардал | 20.000.000 | ТББ, мэргэжлийн холбоо, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлсэн байна | НЗДТГ | Мэргэжлийн бусад байгууллага |
| | 24 | Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ. | Жилдээ | Батлагдсан төсөв | | Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгдөг болсон байх | НЗДТГ | Төрийн үйлчилгээний байгууллага |
| **Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | | | |
| 4.1.3.1 .Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | 25 | Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгоно. | Жилдээ | | | Өнөөгийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, санал боловсруулсан байх | | Холбогдох байгууллага |
| | 26 | Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, | Жилдээ | | | Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах | | Засаг дарга нар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулна. | | | | боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх | | |
| 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 27 | Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна. | Жилдээ | | | Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх | | Бүх шатны төрийн байгууллага |
| | 28 | Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нэмэгдүүлнэ. | Жилдээ | | | Тусгай сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх | | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| 4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 29 | Нийслэлийн 2021 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах ажлыг зохион байгуулна. | 4 дүгээр улиралд | | | Нийслэлийн төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусгасан байх | Санхүү, төрийн сангийн хэлтэс | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |
| 4.1.3.6. нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох | 30 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад дотоод аудит, хяналт шалгалтыг хийх, дүгнэлт, зөвлөмж өгнө. | Жилдээ | | | | Нийслэлийн Дотоод Аудитын газар | |
| | 31 | Нийслэлийн 2021 оны төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэнэ. | 4 дүгээр улиралд | | | Цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах мэдээллийг хүргэсэн байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Холбогдох бусад байгууллагууд |
| 4.1.3.7 .аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | 32 | Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын удирдлага, санхүү хариуцсан албан хаагчдад төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна. | 4 дүгээр улиралд | | | | Нийслэлийн Дотоод Аудитын газар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.4.1. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх | 33 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-т заасны дагуу худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан төсөл, арга хэмжээг Төрийн цахим худалдан авах ажиллагааны системээр дамжуулан зохион байгуулж, www.tender.gov.mn, www.ub-procurement.mn сайтуудад тендерийн баримт бичиг холбогдох мэдээллийг файл хэлбэрээр шууд татан авч үзэх боломжтой байдлаар байршуулна. | Жилдээ | | | Сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн ил тод байдлыг хангасан байх | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | |
| | 34 | Эрх бүхий байгууллагаас зөрчилтэй дүгнэлт авсан буюу дахин зарлах, дахин үнэлгээ хийх, тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж дахин зарлахаар шийдвэрлэгдсэн ажлын бүртгэл үүсгэж, тоог бууруулна. | Тухай бүр | | | Нэгдсэн бүртгэл үүссэн байх | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | |
| | 35 | Худалдан авах ажиллагааны чиглэлээр сайн туршлага солилцох уулзалт, сургалтыг зохион байгуулна. | 2 дугаар улиралд | Батлагдсан төсөв | 4 500 000 | Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байх | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | Холбогдох бусад байгууллага |
| Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.7.1.Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан | 36 | Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна. | Жилдээ | АТҮХ-ийг хэрэгжүүлэх зардлаас | | Сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байх | Нийслэлийн ЗДТГ | ТББ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих | | | | | | | | |
| 4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | 37 | Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлнэ. | Жилдээ | | | Хяналт тавих боломж бүрдсэн байх | Төрийн бус байгууллагууд | |
| | 38 | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлнэ. | Жилдээ | | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төсөл, хөтөлбөрийн хяналт зохицуулалтын хэлтэс | Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд |
| Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 39 | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан дүрст сурталчилгааг хийнэ. | Жилдээ | АТҮХ-ийн хэрэгжүүлэх зардал | 14.400.000 | Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага |
| | 40 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллана. | Жилдээ | АТҮХ-ийн хэрэгжүүлэх зардал | 25.750.000 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ННЗБ-ууд |
| 4.1.10.2.боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, | 41 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр | Жилдээ | Холбогдох зардал | | Сурагчдын нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр болон | Нийслэлийн Боловсролын газар | Дүүргүүдийн Боловсролын хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах | | сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | | | | хэрэглэгдэхүүнийг боловсруулж туршсан байх | | |
| | 42 | Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна. | Жилдээ | | | Хүүхэд, залуучуудын шударга зан чанар, ёс суртахууны үнэлэмж дээшилсэн байх | Хүүхэд, Гэр бүл, залуучуудын хөгжлийн газар | Холбогдох бусад байгууллагууд |